



# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
доорх хаягаар харилцана уу:**

Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр  
Утас: 70543156  
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Аудитор Б.Дарханбат  
Утас: 70543151  
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Хаяг:  
Сүмбэр сум, 3 дугаар баг, Нутгийн  
удирдлагын ордон 2 дугаар давхар

## Аудитын тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил .....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	7
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....	11
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....	11
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	12
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	12
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	12
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.12	Шилэн дансны мэдээлэл .....	15
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	15
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	15
3	Менежментийн захидал .....	17
3.1	«management_zurchil1» .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2	«management_zurchil2» .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	21
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	21
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	23
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	25
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	28

## **1 Аудитын гэрчилгээ**

---

*Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах*

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн аудитын тайланг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Мөнх-Одод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 сарын 21-нээс 2018 оны 03 сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Дарханбат хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03 сарын 21-ний өдрийн 01/201 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

2017 онд Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан бөгөөд Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газар нь салбарын хэмжээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх
2. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж үйлчилгээнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр нэгдсэн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх
3. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд нийгмийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх
4. Аймгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээний тасралтгүй, тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх
5. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлэх
6. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх
7. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог хангаж, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх

8. Эрүүл мэндийн салбарын төсөв, төлөвлөлтийн уялдааг сайжруулах, эрх шилжүүлэх хүрээнд төлөөлөн хэрэгжүүлэх
9. Эрүүл мэндийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдүүлэх гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн газар”-ын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн салбар байгууллагууд орон нутагтаа мөрдөх НБББББ боловсруулж мөрдөж ажиллаагүй байна.

Аудитын явцад судалсан дотоод хяналтаар өмнөх оны санхүүгийн тайланд илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргасан, хамаарал бүхий этгээдийг томилсон, кассын орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй, орлого нуун дарагдуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн нь дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн

үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэн гаргахдаа Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу нэгтгэн гаргаагүй бөгөөд аудитын явцад уг журмын дагуу тайланг нэгтгүүллээ. Тайлан нэгтгэх үйл ажиллагаанд сангийн яамны цахим нэгтгэлийн програм хангамж ашиглажээ.

Нэгтгэсэн тайланд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн програмын ашиглалтын хугацаа дуусч, санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг хангахгүй байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 23 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 7 асуудал эрсдэл өндөр, 5 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 36 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 7 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгосон нь нийт хөрөнгө болон орлогоос тооцоход бодитой бус гэж үзсэнтэй холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,135,343.3 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь 31,353.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Төлөвлөлтийн шатанд 1%-иар тогтоосон хувь хэмжээг гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Байгууллагын үйл ажиллагаа орчин нөхцлийн хувьд зарим материаллаг зүйлс илэрсэн болно.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 9 чиглэлээр 22 эрсдэлтэй асуудалд 22 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100% буюу 15 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	4	9,523.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	232.3	
3	Албан шаардлага өгсөн	4	40,546.8	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	1	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		11	50,302.2	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.



Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

1. Тайлант хугацаанд аймгийн ОНХС-аас сургалтын арга хэмжээнд зориулан 1,044.0 мянган төгрөгийг олгосон бөгөөд сургалтад хамрагдаагүй буюу гүйцэтгэл гараагүй байхад шууд зардлаар бүртгэсэн байна.  
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

2. Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 8,039.9 мянган төгрөгийн зардлыг үйл ажиллагааны мөнгөн зардлаар тайлагнасан байна.  
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, СС-ын 2006 оны 388-р тушаалын 3 дугаар хавсралт 6 дугаар хэсгийн 6.9 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

3. Цалингийн арга хэмжээний суутгалыг нийт олгох цалингаас суутгасан боловч 316.8 мянган төгрөгөөр цалингийн зардлыг бууруулах бичилт хийсэн байна.  
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

4. Санхүүгийн байдлын тайланд 20.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг бүртгээгүй байна.  
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

5. Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр зөвхөн өмч хамгаалах байнгын зөвлөлийн болон хурлын тэмдэглэлийг үндэслэн бараа материалын мал амьтад данснаас 7,686.1 мянган төгрөгийн малыг хассан байна.  
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Данснаас хассан хөрөнгийг буцаан орлогод бүртгэж, хүчин төгөлдөр эрхийн акт, хуулийн үндэслэлтэй шийдвэр гарсан тохиолдолд данснаас хасах, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

6. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,837.0 мянган төгрөгийн ХХОАТ төлсөн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 05 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

7. Тус байгууллагын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийн дагуу аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн бөгөөд уг шалгалтаар нийтдээ 16,497.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнээс 3,215.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүртгэлд тусгаагүй зарцуулсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоогдсон байна. Өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын хавсралтын 2.6-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг бүрэн төвлөрүүлэх, кассын орлогыг дур мэдэн зарцуулахгүй, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

8. Тайлант хугацаанд бэлэн мөнгөөр касст тушаагдсан орлогоос 9,823.7 мянган төгрөгийг мөнгөн кассын журамд заасны дагуу төрийн сангийн дансанд хугацаанд нь төвлөрүүлээгүй, кассаас бэлнээр зарцуулсан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын хавсралтын 2.6-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг мөнгөн кассын үйл ажиллааны журмын дагуу төвлөрүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

9. Нэгдсэн эмнэлгийн дарга С.Ариунгэрэл нь хамаарал бүхий этгээд буюу өөрийн төрсөн дүү болох С.Мөнхгэрэлийг аж ахуйн даргын албан тушаалд томилон 4,200.2 мянган төгрөгийн цалин, НДШ төлсөн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, хөдөлмөрийн тухай хуулийн 27.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хамаарал бүхий этгээдийг ажлаас чөлөөлөх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

10. Санхүүгийн програмын ашиглалтын хугацаа дууссан, холбогдох хууль, журмын дагуу шинэчлэлт бүрэн хийгдээгүй, тайлан бэлтгэн гаргах стандартын шаардлага хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтын хугацаа дуусч шаардлага хангахгүй байгаа програм хангамжийг актлах, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж буй санхүүгийн програмыг шинэчлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

11. Тус эмнэлгийн ерөнхий нягтлан бодогч О.Улам-ундрах, тооцооны нягтлан бодогч Б.Цэрэнбат, кассын нярав С.Сайнбилэг нар нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс дээрх зөрчлүүд нь давтагдан гарсан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10, МУЕА-ын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

12. Орон нутаг дахь салбарын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх НБББББ байхгүй бөгөөд одоогийн мөрдөж буй НБББББ нь стандарт шаардлага хангахгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтыг бүрэн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутаг дахь салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөх НБББББ-ийг боловсруулж мөрдүүлэх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

13. Ажилчдад илүү тооцож олгосон 16.7 мянган төгрөгийн цалинг буцаан суутгасан боловч Татварын хэлтэст шилжүүлж, зориулалт бусаар зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулагдсан 16.7 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичив.

14. Ажлаас халагдсан ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс 215.6 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 15-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас халагдсан ажилтанд ээжлийн амралтын 215.6 мянган төгрөгийг буцаан олгуулахаар төлбөрийн акт бичив.

15. Эрүүл мэндийн газар нь 2017 оны АИТХ-ын 39 дүгээр тогтоолоор 10,025.3 мянган төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хассан боловч

нэг ч хөрөнгө актлаж устгаагүй, устгалын акт үйлдээгүй, данснаас хассан хөрөнгийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын хавсралтын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай зориулалтын бараа материалыг үнэн зөв бүртгэх тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### **2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал**

1. Ажлаас халагдсан ажилтантай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс 215.6 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 15-т заасныг тус тус зөрчсөн байна.

2. Ажилчдад илүү тооцож олгосон 16.7 мянган төгрөгийн цалинг буцаан суутгасан боловч Татварын хэлтэст шилжүүлж, зориулалт бусаар зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

### **2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал**

1. Тус байгууллагын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийн дагуу аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн бөгөөд уг шалгалтаар нийтдээ 16,497.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнээс 3,215.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүртгэлд тусгаагүй зарцуулсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоогдсон байна. Өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 154 дүгээр зүйлийн 14.4.5, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын хавсралтын 2.6-д заасныг тус тус зөрчсөн байна.

2. Тайлант хугацаанд бэлэн мөнгөөр кассст тушаагдсан орлогоос 9,823.7 мянган төгрөгийг мөнгөн кассын журамд заасны дагуу төрийн сангийн дансанд хугацаанд нь төвлөрүүлээгүй, кассаас бэлнээр зарцуулсан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын хавсралтын 2.6-д заасныг тус тус зөрчсөн байна.

3. Нэгдсэн эмнэлгийн дарга С.Ариунгэрэл нь хамаарал бүхий этгээд буюу өөрийн төрсөн дүү болох С.Мөнхгэрэлийг аж ахуйн даргын албан тушаалд томилон 4,200.2 мянган төгрөгийн цалин, НДШ төлсөн байх тул хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хамаарал бүхий этгээдийг ажлаас чөлөөлөх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.
4. Эрүүл мэндийн газар нь 2017 оны АИТХ-ын 39 дүгээр тогтоолоор 10,025.3 мянган төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хассан боловч нэг ч хөрөнгө актлаж устгаагүй, устгалын акт үйлдээгүй, данснаас хассан хөрөнгийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын хавсралтын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

### **2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Тус эмнэлгийн ерөнхий нягтлан бодогч О.Улам-ундрах, тооцооны нягтлан бодогч Б.Цэрэнбат, кассын нярав С.Сайнбилэг нар нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс дээрх зөрчлүүд нь давтагдан гарсан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10, МУЕА-ын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6-т заасныг зөрчсөн байна.

### **2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй.**

#### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 59,724.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9,421.5 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 232.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 40,547.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 9,523.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### **2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ ИЛРЭЭГҮЙ.**

### **2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн салбарын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2,682,121.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>1</b>	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,682,121.6	2,658,946.4	-0.86%	-23,175.2
<b>1.1</b>	Урсгал зардал	2,682,121.6	2,658,946.4	-0.86%	-23,175.2
<b>1.2</b>	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
<b>1.3</b>	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
<b>2</b>	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,682,121.6	2,658,966.6	-0.86%	-23,155.0
<b>2.1</b>	Улсын төсвөөс санхүүжих	1,243,498.3	1,219,415.0	-1.94%	-24,083.3
<b>2.2</b>	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,382,948.0	1,382,948.0	0.0%	0.0
<b>2.3</b>	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	55,675.3	56,603.6	1.08%	928.3.

Төсөвт зардлын гүйцэтгэл 99.14% байгаа нь хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 1 удаагийн тэтгэмж урамшууллын зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар” нь 2017 онд улсын төсвөөс 1,123,841.4 мянга, Нийгмийн даатгалын сангаас 1,382,948.0 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 55,675.3 мянга, нийт 2,562,464.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд төсвийн тодотголоор 119,656.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт 2,682,121.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдан 2,682,121.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд 2,658,966.6 мянган төгрөг зарцуулж, 928.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 24,083.3 мянган төгрөгийг санхүүжилтээс төсөвт буцаан төвлөрүүлж 20.2 мянган төгрөгийн кассын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд төсөвт 2 удаа тодотгол хийсэн бөгөөд хийсэн бөгөөд төсвийн зарим зардлыг 142,294.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 22,637.4 мянган төгрөгөөр бууруулан баталж, өссөн дүнгээр нийт төсвийг 119,656.9 мянган төгрөгөөр нэмж баталсан байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 928.3 мянган төгрөг буюу 1.08%-иар давуулан биелүүлсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд санхүүжилт 1,241,512.8 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,382,948.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал 348,887.3 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 54,257.1 мянга, арга хэмжээний орлого 316.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 56,603.6 мянга, нийт 3,084,525.7 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.



Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар санхүүжилт 1,241,512.8 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,382,948.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 56,603.6 мянга нэмэлт санхүүжилт дансны орлого 54,257.1 мянга, нийт 2,735,321.5 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Салбарын хэмжээнд тайлант оны эхэнд 7,365.8 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэнээс оны эцэст 1,064.6 мянган төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд энэ нь ХХОАТ-ын илүү төлөлт болон дурангийн сувилагч бэлтгэх сургалтын төлбөрийг урьдчилж төлсөн зардлаар тайлагнасантай холбоотой байна.

Өглөгийн эхний үлдэгдэлд 22,227.4 мянган төгрөг бүртгэгдсэн бөгөөд оны эцэст 5,077.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь хоолны зардлаас өмнөх оны өр барагдуулсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө нийт 352,251.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 438,151.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тухайлбал:

Барилга, байгууламж данс аймгийн ОНХС-аас хийгдсэн барилгын их засвар 80,000.0 мянга, тээврийн хэрэгсэл данс ЭМС-ын 2017 А/237 тоот тушаал, АИТХ-ын 2017 оны 04 тоот тогтоолоор автомашин 35,919.6 мянга, машин тоног төхөөрөмж данс ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 215,102.9 мянга, ДЗОУБ-аас 11,374.4 мянга, өөрийн хөрөнгөөр 8,854.9 мянга, нийт 236,332.2 мянга, программ хангамж данс 1,000.0 мянга, нийт 352,251.8 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2017 19 дүгээр тогтоолоор 39,000.0 мянган төгрөгийн автомашин, 2017 оны 39 дүгээр тогтоолоор 10,025.3 мянга 59 дүгээр тогтоолоор 386,823.9 мянга, Орон нутгийн өмчийн албаны 2017 оны 242 тоот албан бичгээр 2,302.3 мянган төгрөгийн компьютер шилжүүлж нийт 438,151.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна. Дээрх данснаас хассан автомашиныг орон нутгийн өмчийн алба хураан авч, дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг орон нутгийн орлогод оруулсан бол нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж данснаас актлагдсан 28 нэр төрлийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017 оны 02 дугаар хурлын шийдвэрээр үнэ тогтоон эргэлтийн хөрөнгөнд бүртгэн ашиглаж байна. Эрүүл мэндийн газрын тоног төхөөрөмжийн данснаас хасагдсан 10,025.3 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан боловч бараа материалд бүртгэлгүйгээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.

